



I-XII/2021

Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 14



**Бүх төрлийн тээврийн орлого 2021 оны 4 дүгээр улиралд 358.8 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 7.6 (2.2%) тэрбум төгрөгөөр өслөө**

## Бүх төрлийн тээвэр

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2021 онд 49.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 11.1 (18.5%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 12.5 (41.0%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2021 онд 107.2 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оноос 19.4 (15.3%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 17.6 (14.2%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 1. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,  
жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021*
Тээсэн ачаа, сая тонн	69.0	60.3	49.2
Зорчигчид, сая хүн	173.0	126.5	107.1
Тээврийн орлого, тэрбум төгрөг	2 003.5	1 498.5	1 385.6

Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2021 оны 4 дүгээр улиралд, өмнөх улирлаас 764.1 (6.9%) мянган тонноор буурсан бол зорчигчид 18.6 (60.6%) сая хүнээр өссөн байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2021 онд 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 112.5 (7.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Авто тээврийн орлого 150.5 (26.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Харин бүх төрлийн тээврийн орлого 2021 оны 4 дүгээр улиралд 358.4 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 7.2 (2.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## Авто замын тээвэр

Авто тээврээр 2021 онд 18.0 сая тонн ачаа, давхардсан тоогоор 106.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 12.5 (41.0%) сая тонн, зорчигчид 17.6 (14.2%) сая хүнээр буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 12.1 сая тонн буюу 45.2 хувь, зорчигч тээврийн бууралтад нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 15.5 (13.8%) сая хүнээр буурсан нь тус тус нөлөөлсөн байна.

Харин авто замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 274.2 (8.4%) мянган тонноор буурч, зорчигчид 18.4 (60.0%) сая хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 2. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,  
жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2019	2020	2021*
Тээсэн ачаа, сая тонн	40.8	30.5	18.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	33.6	26.8	14.7
Зорчигчид, сая хүн	168.4	124.1	106.6
Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчид	152.5	112.1	96.6
Тээврийн орлого, тэрбум төгрөг	796.1	564.4	413.9


Авто тээврийн салбарын орлого 2021 онд 413.9 тэрбум төгрөгт болж, өмнөх оноос 150.5 (26.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Мөн авто тээврийн орлого 2021 оны 4 дүгээр улиралд 101.3 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 677.4 (0.7%) сая төгрөгөөр буурсан байна.

**Төмөр замын тээвэр**

Төмөр замын тээврээр 2021 онд 31.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 1.4 (4.5%) сая тонноор өсжээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд дотоодод тээсэн ачаа 1.6 (14.3%) сая тонн, импортын ачаа 335.4 (11.1%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 12 дугаар сард 1.9 сая тонн болж, өмнөх сараас 740.6 (28.0%) мянган тонноор буурчээ.

ХҮСНЭГТ 3. ТӨМӨР ЗАМААР ДОТООД, ГАДААДАД ТЭЭСЭН АЧАА,  
бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст


Үзүүлэлт	2019	2020	2021*
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Уул уурхайн бүтээгдэхүүн	83.2	83.3	81.4
Барилгын материал	9.9	10.0	12.7
Мод, модон материал	0.6	0.5	0.4
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.9	1.0
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.5	0.9	0.7
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.2	1.5	1.1
Бусад	2.7	2.9	2.7

Төмөр замын тээврээр 2021 онд уул уурхайн бүтээгдэхүүн 428.7 (2.3%) мянган тонн, барилгын материал 731.9 (32.3%) мянган тонн, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 17.7 (8.5%) мянган тонноор өсөж, харин хар төмөр 74.3 (22.6%) мянган тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 28.5 (14.1%) мянган тонноор тус тус буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2021 онд 361.0 (давхардсан тоо) мянга болж, өмнөх оноос 1.6 (81.6%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад ковид-19 өвчнөөс үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээврийг хязгаарласан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2021 онд 771.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1.1 (0.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд нүүрс, барилгын материал болон хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД,  
мянган хүн, сараар




Төмөр замын тээврийн орлого 2021 оны 12 дугаар сард 44.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 22.8 (34.0%) сая төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад төмрийн хүдэр, зэс болон барилгын материал тээвэрлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

## Агаарын тээвэр

Агаарын тээврээр 2021 онд 6.4 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.7 (2.3 дахин) мянган тонноор өссөн байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, тонн, сараар




Агаарын тээврээр 2021 онд дотоодод 15.1 тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 82.4 (84.5%) тонноор буурсан байна.

Харин олон улсад тээсэн ачаа 6.4 мянган тонн болж, өмнөх оноос 3.8 (2.4 дахин) мянган тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2021 оны 12 дугаар сард 1.4 мянган тонн болж, өмнөх сараас 204.0 (16.5%) тонноор өссөн байна.

ЗУРАГ 4. АГААРЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, мянган хүн, сараар



Агаарын тээврээр зорчигчид 2021 онд 198.5 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оноос 249.0 (55.6%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр зорчигчид 2021 оны 12 дугаар сард 34.5 мянга болж, өмнөх сараас 8.0 (30.1%) мянган хүнээр өссөн байна. Энэхүү

өсөлтөд Улаанбаатар-Бангкок-Улаанбаатар чиглэлийн зорчигчид 4.8 дахин, Улаанбаатар-Пукет-Улаанбаатар чиглэлийн зорчигчид 3.2 дахин, Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар чиглэлийн зорчигчид 59.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2021 онд 98.3 мянган хүн болж, өмнөх оноос 187.4 (65.6%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Мөрөн чиглэлийн зорчигчид 86.4 хувь, Оюутолгой-Даланзадгад чиглэлийн зорчигчид 80.6 хувь, Улаангом чиглэлийн зорчигчид 78.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2021 онд 100.3 мянган хүн болж, өмнөх оноос 61.5 (38.0%) мянган хүнээр буурсан байна. Харин 2021 оны 12 дугаар сард 20.0 мянган хүн болж, өмнөх сараас 5.3 (36.0%) мянган хүнээр өссөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 онд 200.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 36.0 (21.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны 12 дугаар сард өмнөх сараас 8.4 (33.4%) тэрбум төгрөгөөр өсөж, 33.7 тэрбум төгрөг болсон байна. Энэхүү өсөлтөд дотоодын нислэгийн зорчигчид 22.7 хувь, олон улсын нислэгийн зорчигчид 36.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

#### Тооцох аргачлал:

- **Ачаа эргэлт.** Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.
- **Зорчигч эргэлт.** Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
- **Шилжүүлсэн тонн километр.** Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
- **Тээврийн орлого.** Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



#### Эх үүсвэр:

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ

#### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

#### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын  
ахлах статистикч О.Мандахзориг  
Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212

